



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүхбаатар аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СБА-2025/099/-НА-СТА-ТШЗ

| | |
|--|---|
| Цахим хуудас: www.audit.mn Баруун-Урт сум 2025 он | Дарга, тэргүүлэх аудитор: Г.Даваа Утас: 70518396 Аудитын менежер: М.Нарантуяа Утас: 70512123 Аудитор: О.Барчидгүнсэн Утас: 70512123 |
|--|---|

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

| | |
|--|----|
| 1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ | 3 |
| 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ | 5 |
| 4. АУДИТЫН ТАЙЛАН | 13 |
| 4.1 Ерөнхий зүйл | 13 |
| 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт | 13 |
| 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал | 13 |
| 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт | 13 |
| 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт | 14 |
| 4.5.1 Завсрын аудитын талаар | 14 |
| 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал | 14 |
| 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ | 15 |
| 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ | 16 |

Товчилсон үгийн жагсаалт

| | |
|----------|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

6 давхарт, Нутгийн удирдлагын 2 дугаар байр,
Балдан-Осорын гудамж, 7 дугаар баг,
Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг, 22075
Утас: (976) 70518396
Цахим шуудан: sukhbaatar@audit.gov.mn

2025.02.25 № 171
танай _____-ны № _____-т

СҮХБААТАР АЙМГИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА А.ЧУЛУУНБАТ
ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сүхбаатар аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Сүхбаатар аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал 2023 оны тогтоолыг үндэслэн Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд суудалтай намд суудлын мөнгө олгосон нь холбогдох хууль, эрх зүйн зохицуулалтад нийцээгүй байна. Үүний улмаас төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах, санхүүгийн сахилга бат алдагдах, хууль зөрчсөн шийдвэрийг давтан гаргах нөхцөл бүрдэх, улмаар төсвийн хариуцлагын тогтолцоонд сөргөөр нөлөөлж байна.

Аудитын гол асуудал

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ээлжит болон ээлжит бус хуралдааны үеэр төрийн албан хаагчдыг хоолоор хангаж байгаа нь төсвийн зориулалт, хэмнэлтийн зарчимд нийцэхгүй байна. Үүний улмаас төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах,

D:\Бичиг хэрэг\2025\Явсан бичиг\A4 тоот 2025.docx

2225000081

санхүүгийн сахилга бат алдагдах, бусад шаардлагатай зардлуудад санхүүжилтийг төлөвлөх шаардлагатай байна.

Бусад асуудлын хэсэг

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн ажлын төлөвлөгөөг батлуулж, нутаг дэвсгэрийн хэмжээнд сахилга дэг журмыг бэхжүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлжээ.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Г.ДАВАА

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|------------|---|------------------|------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 17,992,275.00 | 23,207,275.00 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 17,992,275.00 | 23,207,275.00 |
| 354 | Хангамжийн материал | 17,992,275.00 | 23,207,275.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 1,110,000.00 | 4,065,000.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 8,148,650.00 | 10,408,650.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 8,733,625.00 | 8,733,625.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 207,262,659.18 | 563,459,787.13 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 207,262,659.18 | 563,459,787.13 |
| 392 | Биет хөрөнгө | 203,199,992.46 | 561,095,953.69 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 15,207,606.00 | 465,207,606.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (5,575,867.34) | (40,473,054.14) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 207,750,000.00 | 207,750,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (186,875,000.20) | (207,750,000.00) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 148,793,360.00 | 154,393,360.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (53,043,930.02) | (85,520,157.69) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 107,411,147.00 | 111,711,147.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (30,467,322.98) | (44,222,947.48) |
| 393 | Биет бус хөрөнгө | 4,062,666.72 | 2,363,833.44 |
| 39301 | Програм хангамж | 7,224,500.00 | 7,224,500.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (3,161,833.28) | (4,860,666.56) |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 225,254,934.18 | 586,667,062.13 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 225,254,934.18 | 586,667,062.13 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 225,254,934.18 | 586,667,062.13 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 43,155,439.00 | 43,155,439.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 43,155,439.00 | 43,155,439.00 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 175,655,737.67 | 537,067,865.62 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 175,655,737.67 | 175,655,737.67 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 361,412,127.95 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 6,443,757.51 | 6,443,757.51 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 225,254,934.18 | 586,667,062.13 |

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|------------|---|---------------------|-----------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 1,516,602,445.20 | 1,949,801,909.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 149,699,345.20 | 419,062,500.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | - | 419,062,500.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | | 419,062,500.00 |
| 122 | Тусламжийн орлого | 149,699,345.20 | - |
| 122001 | Хандив тусламж /дотоод/ | 149,699,345.20 | - |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 1,366,903,100.00 | 1,530,739,409.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 102,648,000.00 | 83,981,009.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 5,000,000.00 | 38,681,009.00 |

| | | | |
|-------------|--|-------------------------|-------------------------|
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 97,048,000.00 | 43,000,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 600,000.00 | 2,300,000.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 1,264,255,100.00 | 1,446,758,400.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 1,264,255,100.00 | 1,446,758,400.00 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 1,427,289,593.43 | 1,588,389,781.05 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,427,289,593.43 | 1,588,389,781.05 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,304,221,805.89 | 1,450,609,394.53 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 456,035,311.19 | 706,511,739.89 |
| 210101 | Үндсэн цалин | 259,868,987.10 | 344,387,837.82 |
| 210102 | Нэмэгдэл | 128,437,041.79 | 261,060,052.07 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 47,040,000.00 | 76,263,440.00 |
| 210104 | Урамшуулал | 20,689,282.30 | 24,800,410.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 56,506,263.68 | 88,312,426.62 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 39,080,089.98 | 62,517,325.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,620,853.18 | 7,090,126.42 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,670,282.40 | 3,545,062.73 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 827,854.08 | 3,032,223.30 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 8,307,184.04 | 12,127,689.17 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 15,496,113.37 | 16,147,882.66 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 599,393.37 | 715,222.66 |
| 210302 | Түлш, халаалт | 11,817,540.00 | 11,645,480.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 3,079,180.00 | 1,898,303.00 |
| 210304 | Байрны түрээс | - | 1,888,877.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 61,424,256.81 | 69,604,157.20 |
| 210401 | Бичиг хэрэг | 5,776,550.00 | 6,760,500.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 43,500,000.00 | 52,000,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 4,022,931.81 | 6,042,676.20 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 8,124,775.00 | 4,800,981.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 69,985,356.75 | 35,980,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 29,990,606.75 | - |
| 210604 | Урсгал засвар | 39,994,750.00 | 35,980,000.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 19,994,000.00 | 25,334,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 19,994,000.00 | 25,334,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 276,037,344.66 | 208,681,789.11 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 270,162,000.00 | 203,236,105.11 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,008,000.00 | - |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 2,000,000.00 | 2,000,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 178,264.00 | 196,264.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 44,000.00 | 50,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 2,645,080.66 | 3,199,420.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 348,743,159.43 | 300,037,399.05 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 202,303,211.00 | 167,341,301.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 57,399,805.00 | 59,930,726.00 |

| | | | |
|-------------|---|-----------------------------|------------------------------|
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 89,040,143.43 | 72,765,372.05 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 123,067,787.54 | 137,780,386.52 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 122,719,686.00 | 137,511,899.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 30,721,500.00 | 36,132,900.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 91,998,186.00 | 101,378,999.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 348,101.54 | 268,487.52 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 348,101.54 | 268,487.52 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | <u>89,312,851.77</u> | <u>361,412,127.95</u> |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 0.32 | - |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 0.32 | - |
| 4 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225) | (0.32) | - |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | <u>89,312,851.45</u> | <u>361,412,127.95</u> |

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|------------|---|-------------------------|-------------------------|
| | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | |
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | <u>1,366,903,100.00</u> | <u>1,530,739,409.00</u> |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 1,366,903,100.00 | 1,530,739,409.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 102,648,000.00 | 83,981,009.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 5,000,000.00 | 38,681,009.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 97,048,000.00 | 43,000,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 600,000.00 | 2,300,000.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 1,264,255,100.00 | 1,446,758,400.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 1,264,255,100.00 | 1,446,758,400.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | <u>1,340,708,100.00</u> | <u>1,520,839,409.00</u> |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,340,708,100.00 | 1,520,839,409.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,217,640,312.46 | 1,383,509,022.48 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 456,035,311.19 | 706,511,739.89 |
| 210101 | Үндсэн цалин | 259,868,987.10 | 344,387,837.82 |
| 210102 | Нэмэгдэл | 128,437,041.79 | 261,060,052.07 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 47,040,000.00 | 76,263,440.00 |
| 210104 | Урамшуулал | 20,689,282.30 | 24,800,410.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 56,506,263.68 | 88,312,426.62 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 39,080,089.98 | 62,517,325.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,620,853.18 | 7,090,126.42 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,670,282.40 | 3,545,062.73 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 827,854.08 | 3,032,223.30 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 8,307,184.04 | 12,127,689.17 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 15,496,113.37 | 16,147,882.66 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 599,393.37 | 766,222.66 |
| 210302 | Түлш, халаалт | 11,817,540.00 | 11,645,480.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 3,079,180.00 | 1,847,303.00 |
| 210304 | Байрны түрээс | - | 1,888,877.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 63,494,743.81 | 68,999,024.20 |
| 210401 | Бичиг хэрэг | 5,972,550.00 | 6,000,000.00 |

| | | | |
|--------|--|-----------------|----------------|
| 210402 | Тээвэр, шатахуун | 43,500,000.00 | 52,000,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 4,022,931.81 | 5,999,076.20 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 9,999,262.00 | 4,999,948.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 69,990,356.75 | 35,000,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 29,990,606.75 | - |
| 210604 | Урсгал засвар | 39,999,750.00 | 35,000,000.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 19,994,000.00 | 24,934,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 19,994,000.00 | 24,934,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 276,829,344.66 | 209,562,674.11 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 270,600,000.00 | 204,116,990.11 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,008,000.00 | - |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 2,000,000.00 | 2,000,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 178,264.00 | 196,264.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 44,000.00 | 50,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 2,999,080.66 | 3,199,420.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 259,294,179.00 | 234,041,275.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 200,750,753.00 | 173,485,366.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 58,543,426.00 | 60,555,909.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 123,067,787.54 | 137,330,386.52 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 122,719,686.00 | 137,061,899.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 30,721,500.00 | 36,132,900.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 91,998,186.00 | 100,928,999.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 348,101.54 | 268,487.52 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 348,101.54 | 268,487.52 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | 26,195,000.00 | 9,900,000.00 |
| 5 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5) | 26,195,000.00 | 9,900,000.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 26,195,000.00 | 9,900,000.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 26,195,000.00 | 9,900,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 26,195,000.00 | 9,900,000.00 |
| 6 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | (26,195,000.00) | (9,900,000.00) |

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын | Дахин үнэлгээний | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооний |
|-----|--|----------------|------------------|-------------------|-------|--------------------------------|
| C01 | 2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 43,155,439.00 | 6,443,757.51 | 175,655,737.67 | - | 225,254,934.18 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - | - |
| C03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 43,155,439.00 | 6,443,757.51 | 175,655,737.67 | - | 225,254,934.18 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | - | - | - | - | - |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | - | - | - | - | - |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - | - |
| C07 | Тайлант үеийн үр дүн | - | - | 361,801,627.81 | - | 361,801,627.81 |
| C08 | 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 43,155,439.00 | 6,443,757.51 | 537,457,365.48 | - | 587,056,561.99 |
| D01 | 2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 43,155,439.00 | 6,443,757.51 | 537,457,365.48 | - | 587,056,561.99 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - | - |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 43,155,439.00 | 6,443,757.51 | 537,457,365.48 | - | 587,056,561.99 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | - | - | - | - | - |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | - | - | - | - | - |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - | - |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | - | - | - | - | - |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | 361,412,127.95 | - | 361,412,127.95 |
| D09 | 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 43,155,439.00 | 6,443,757.51 | 898,869,493.43 | - | 948,468,689.94 |

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|-----------------------|--|-------------------------|-------------------------|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| 1 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 1446758400.00 | 1446489912.48 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1446758400.00 | 1446489912.48 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1390625500.00 | 1390409022.48 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 706806200.00 | 706511739.89 |
| 210101 | Үндсэн цалин | 312050000.00 | 344387837.82 |
| 210102 | Нэмэгдэл | 292456200.00 | 261060052.07 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 81300000.00 | 76263440.00 |
| 210104 | Урамшуулал | 21000000.00 | 24800410.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 88363200.00 | 88312426.62 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 62935000.00 | 62517325.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 6357100.00 | 7090126.42 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3178500.00 | 3545062.73 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3178500.00 | 3032223.30 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 12714100.00 | 12127689.17 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 16148100.00 | 16147882.66 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2500000.00 | 766222.66 |
| 210302 | Түлш, халаалт | 11148100.00 | 11645480.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2500000.00 | 1847303.00 |
| 210304 | Байрны түрээс | 0.00 | 1888877.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 69000000.00 | 68999024.20 |
| 210401 | Бичиг хэрэг | 6000000.00 | 6000000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 52000000.00 | 52000000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 6,000,000.00 | 5,999,076.20 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 5,000,000.00 | 4,999,948.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 35,000,000.00 | 35,000,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 35,000,000.00 | 35,000,000.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 25,000,000.00 | 24,934,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 25,000,000.00 | 24,934,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 215,750,000.00 | 212,362,674.11 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 207,500,000.00 | 204,116,990.11 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 2,000,000.00 | 2,000,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 200,000.00 | 196,264.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 50,000.00 | 50,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 6,000,000.00 | 5,999,420.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 234,558,000.00 | 238,141,275.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 174,000,000.00 | 177,585,366.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 60,558,000.00 | 60,555,909.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 56,132,900.00 | 56,080,890.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 56,132,900.00 | 56,080,890.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 36,132,900.00 | 36,132,900.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 20,000,000.00 | 19,947,990.00 |
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 1,446,758,400.00 | 1,446,489,921.48 |
| 1320 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 1,446,758,400.00 | 1,446,489,921.48 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 1,446,758,400.00 | 1,446,489,921.48 |
| 61 | БАЙГУУЛЛАГЫН ТОО | 1.00 | 1.00 |
| 610001 | Төсвийн байгууллага | 1.00 | 1.00 |
| 62 | АЖИЛЛАГСАДЫН ТОО | 16.00 | 16.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 5.00 | 5.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 8.00 | 8.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 3.00 | 3.00 |
| 65 | ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ | 16.00 | 16.00 |
| 650001 | Төрийн захиргааны албан хаагч (ТЗ) | 12.00 | 12.00 |

| | | | |
|--------|--|------|------|
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 3.00 | 3.00 |
| 650011 | Улс төрийн албан хаагч (УТ) | 1.00 | 1.00 |

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|------------|---|---------------|
| I | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 91,081,009.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 91,081,009.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 10,100,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 10,100,000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 10,100,000.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 80,981,009.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 80,981,009.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 80,981,009.00 |
| II | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 83,981,009.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 83,981,009.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 38,681,009.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 43,000,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 2,300,000.00 |

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 57,825.4 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс, 4,397.4 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, зардлын үр ашгийн дээшлүүлэх 53,428.0 мянга төгрөгийн 3 албан шаардлага хүргүүлээ.

3.1 Төлбөрийн акт

Аймгийн ИТХ-ын анхдугаар болон хүндэтгэлийн хуралдаанд оролцогчдод хүндэтгэл үзүүлэх зорилгоор 4,397.4 мянган төгрөгийг давхардуулан, илүү зардал гаргаж төсвийг үр ашиггүй зарцуулсан. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 /батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах/, 41.2.3 /төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах/ Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4², Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2 дахь заалттай заалттай тус тус нийцэхгүй байна

3.2 Албан шаардлага

3.2.1 Тус байгууллага нь сумдын ИТХ-ын дарга, нарын бичгийн дарга, мэргэжилтнүүд, зөвлөл, хороодын гишүүдийг чадавхжуулах сургалт зохион байгуулсан бөгөөд хоолны зардалд 17,282.5 мянган төгрөг зарцуулсан. Гэвч дээрх албан тушаалтнууд албан томилолтоор сургалтад оролцсон тул хоолны зардал нь томилолтын зардалд багтаж байгаа бөгөөд төсвөөс давхардуулан зарцуулалт хийгдсэн, төсвийг зөв удирдах шаардлагад нийцээгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.3³, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4⁴, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2 дахь заалттай нийцэхгүй байна

3.2.2 Аймгийн ИТХ-аас ээлжит болон ээлжит бус хуралдаан зохион байгуулахад төлөөлөгч болон төр захиргааны байгууллагын холбогдох албан тушаалтнууд хуралд оролцсон, төлөөлөгч нарын хоолны зардал 14,956.1 мянган төгрөг, төрийн албан хаагч нарын хоолны зардал 20,542.9 мянган төгрөг болж нийт 35,499.0 мянган төгрөг зарцуулагдсан. Гэвч бүх төрийн албан хаагчид хоол унааны хөнгөлөлт эдэлдэг бөгөөд хуралдаанд оролцсон төрийн албан хаагчдын хоолны зардал төсвөөс давхардуулан зарцуулсан нь үр ашиггүй, зориулалтын бус зарцуулалт болжээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн

41.2.3⁵, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4⁶, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2 дахь заалттай нийцэхгүйд албан шаардлага хүргүүлээ.

3.2.3 Сүхбаатар аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал 2023 оны 4 дүгээр тогтоолыг дагаж, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд суудалтай Ардчилсан намд 20,000.0 мянган төгрөгийн суудлын мөнгө олгосон нь Төсвийн зориулалт, үр ашигтай байх зарчимтай нийцээгүй, зөрчил байна. Энэхүү зардал нь төсвийн зориулалтад нийцээгүй, орон нутгийн чиг үүрэгт хамаарахгүй, төсвийн хүрээнд зөв зарцуулалт хийгээгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.2, 16 дугаар зүйлийн 16.5.5, 41 дүгээр зүйлийн 41.2.3 , Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4, Нягтлан бодох бүртгэлийн

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

² энэ хуулийн 17.1-д заасан эрх бүхий этгээдийн хууль ёсны шаардлагыг цаг тухайд нь бүрэн хэрэгжүүлэх

³ төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах

⁴ хуулиар зөвшөөрөөгүй бусад

⁵ төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах

⁶ хуулиар зөвшөөрөөгүй бусад

тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2, Улс төрийн намын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.5, 34.6.3 дахь заалттай тус тус нийцээгүй байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|--|-------------|-----------------|---------------|----------------|-----------------|-----------------|----------|-----|--------------------------------------|-----|---|-----|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Аймгийн ИТХ-ын анхдугаар болон хүндэтгэлийн хуралдаанд оролцогчдод хүндэтгэл үзүүлж төсвийг үр ашиггүй зарцуулсан | 1 | 4397.4 | 1 | 4397.4 | | | | | | | | |
| ИТХ-ын сургалт зохион байгуулсан бөгөөд хоолны зардалд 47,595.9 мянган төгрөг зарцуулж томилолтын зардалтай давхардах асуудал үүссэн | 1 | 17,282.5 | | | 1 | 17,282.5 | | | | | | |
| Аймгийн ИТХ-аас ээлжит болон ээлжит бус хуралдаан зохион байгуулахад төлөөлөгч болон төр захиргааны байгууллагын холбогдох албан тушаалтнууд хуралд оролцсон. Хуралд оролцсон төлөөлөгч нарын хоолны зардал 14,956.1 мянган төгрөг, төрийн албан хаагч нарын хоолны зардал 20,542.9 мянган төгрөг болж нийт 35,499.0 мянган төгрөг зарцуулагдсан | 1 | 16,145.5 | | | 1 | 16,145.5 | | | | | | |
| Намд суудлын мөнгө олгосон | 1 | 20,000.0 | | | 1 | 20,000.0 | | | | | | |
| Дүн | 4 | 57,825.4 | 1 | 4,397.4 | 3 | 53,428.0 | 2 | | | | | |